



СИ ПИ ТИ ЭЙ АУДИТ ХХК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Түнэл Илч ХХК-ийн 2023 оны
жилийн эцсийн санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2024/13/НА-СТА-ОНА

Цахим хуудас:

www.audit.mn

Хөвсгөл аймаг

2024 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн Аудитын Газрын
Дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatar@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Давааням
Утас: 88095436 Цахим хаяг: davaanyamb@audit.gov.mn

Аудитыг гүйцэтгэсэн: Си Пи Ти Эй Аудит ХХК-ийн
Захирал: Ч.Энхчимэг
Утас: 77233030 Цахим хаяг: info@cptaaudit.mn

Аудитор: Д.Мядагмаа
Утас: 77233030 Цахим хаяг: info@cptaaudit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

НЭГ. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvs gul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024.03.15 № 01/261
танай _____ -ны № _____ -т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН “ТҮНЭЛ ИЛЧ”
ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Ж.БАДРАЛ ТАНАА

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Түнэл Илч” ХХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, болон тодруулгуудад аудит хийлээ.

“Түнэл Илч” ХХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Төлөөлөн удирдах зөвлөлийн баталсан орлого, үр дүнгийн тайлангийн төлөвлөгөө нь оны эхэнд 334.7 сая төгрөгийн борлуулалт, 319.3 сая төгрөгийн зардалтай, 15.4 сая төгрөгийн ашигтай байхаар төлөвлөгдсөн ч оны дундуур 9.8 сая төгрөгийн орлого нэмэгдүүлэх тодотгол хийж, 25.2 сая төгрөгийн ашигтай ажиллагаар баталсан байна.

Аудитын гол асуудал

Аудитаар нийт 107.4 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 7.9 сая төгрөгийн алдааг залруулж, 99.5 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлж ажилласан.

Бусад асуудлын хэсэг

Түнэл Илч ХХК нь Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 12 сарын 23-ны өдрийн 05 дугаар тогтоолоор 2023 оны бизнес төлөвлөгөөг баталж, 2023 оны 12 сарын 20-ны өдрийн 05 дугаар тогтоолоор нийт орлогыг 344.5 сая төгрөгөөр, нийт зардлыг 319.3 сая төгрөгөөр байхаар нэмэлт тодотгол хийснээс 97.0 хувийн орлогын гүйцэтгэлтэй байна.

Хөвсгөл аймгийн ИТХ-аар батлагдсан Эдийн засгийн зорилтот түвшний төлөвлөгөөнд суурилж, ТУЗ бизнес төлөвлөгөөгөө шинэчлэн боловсруулж, баталдаг байна.

5724040642

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

ХОЁР. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2023 оны 01-сарын 01	2023 оны 12-р сарын 31
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	3,430,500.73	789,006.81
1.1.2	Дансны авлага	1,671,250.00	1,624,788.00
1.1.6	Бараа материал	46,546,575.00	41,553,420.70
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	51,648,325.73	43,967,215.51
1.2.1	Үндсэн хөрөнгө	525,842,003.36	509,752,258.66
1.2.2	Биет бус хөрөнгө	24,758,549.75	24,758,549.75
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	550,600,553.12	534,510,808.41
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	602,248,878.85	578,478,023.92
2.1.1.1	Дансны өглөг	73,360.00	6,328,510.01
2.1.1.3	Татварын өр	1,181,119.75	16,554,573.03
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	1,254,479.74	22,883,083.04
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	21,811,769.83	20,895,915.49
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	21,811,769.83	20,895,915.49
2.2	Өр төлбөрийн нийт дүн	23,066,249.57	43,778,998.53
2.3.1	Өмч: - төрийн	178,862,641.08	178,862,641.08
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	174,175,791.10	174,175,791.10
2.3.8	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	279,059,624.00	293,679,624.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	-52,915,426.90	-112,019,030.79
2.3.11	Эзэмшигчдийн өмчийн дүн	579,182,629.28	534,699,025.39
2.4	Өр төлбөр ба эзэмшигчдын өмчийн дүн	602,248,878.85	578,478,023.92

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2023 оны 01-сарын 01	2023 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	326,777,629.35	333,596,581.08
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	317,946,715.82	365,610,680.59
3	Нийт ашиг (алдагдал)	8,830,913.53	(32,014,099.51)
6	Хойшлогдсон татварын орлого	-	915,854.34
10	Ерөнхий ба удирдлагын зардал	27,115,810.99	27,492,617.00
12	Бусад зардал	283,000.00	7,200.00
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(18,567,897.46)	(58,598,062.17)
19	Орлогын татварын зардал	21,811,769.83	505,541.72
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(40,379,667.29)	(59,103,603.89)

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	НИЙТ ДҮН
2022 оны 1-р сарын 1- ний үлдэгдэл	178,862,641.08	174,175,791.10	208,969,623.00	-12,535,759.61	549,472,295.57
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0	0	0	-40,379,667.29	-40,379,667.29
Өмчид гарсан өөрчлөлт	0	0	70,090,001.00	0	70,090,001.00
2023 оны 01-р сарын 01- ний үлдэгдэл	178,862,641.08	174,175,791.10	279,059,624.00	-52,915,426.90	579,182,629.28
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0	0	0	-59,103,603.89	-59,103,603.89
Өмчид гарсан өөрчлөлт		0	14,620,000.00		14,620,000.00
2023 оны 12-р сарын 31- ний үлдэгдэл	178,862,641.08	174,175,791.10	293,679,624.00	-112,019,030.79	534,699,025.39

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 01- сарын 01	2023 оны 12-р сарын 31
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	354,076,255.88	367,002,701.20
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	351,324,346.88	366,843,701.20
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	112,599.00	
	Бусад мөнгөн орлого	2,639,310.00	159,000.00
1.2	Мөнгөн зарлага (-)	349,967,641.68	369,644,195.12
	Ажиллагчдад төлсөн	113,068,511.81	111,440,858.00
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	32,342,472.19	37,426,849.48
	Бараа материал худалдан авахад төлсөн	103,606,788.00	82,722,922.50
	Ашиглалтын зардалд төлсөн	26,997,268.05	38,891,311.80
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	29,439,040.00	62,902,310.00
	Татварын байгууллагад төлсөн	32,875,041.63	21,484,518.84
	Даатгалын төлбөрт төлсөн	3,223,300.00	2,872,000.00
	Бусад мөнгөн зарлага	9,654,530.00	11,903,424.50
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	4,108,614.20	-2,641,493.92
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	2,869,304.20	-2,641,493.92
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	561,196.53	3,430,500.73
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,430,500.73	789,006.81

2.5 ТУЗ-аар батлагдсан бизнес төлөвлөгөө, гүйцэтгэл

/төгрөгөөр/

Зардлын төрөл		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт хувиар
1	Халаалтын орлого	319,863,892.00	319,527,472.00	(336,420)	100%
2	Цэвэр усны орлого	5,000,000.00	272,727.27	(4,727,273)	5%
3	Бохир усны орлого	3,000,000.00	1,232,745.45	(1,767,255)	41%
4	Халуун усны орлого	5,000,000.00	536,363.64	(4,463,636)	11%
5	Хогний төлбөрийн орлого	1,800,000.00	809,090.91	(990,909)	45%
6	Бусад орлого	9,840,000.00	11,218,181.81	1,378,182	114%
Орлогын дүн		344,503,892.00	333,596,581.08	(10,907,311)	97%
1	Цалин хөлс, нэмэгдэл, урамшуулал	131,214,544.00	135,652,919.00	4,438,375	103%
2	НДШимтгэлийн зардал	21,348,330.90	21,963,771.48	615,441	103%
3	Нүүрс	63,000,000.00	46,098,125.00	(16,901,875)	73%
4	Шатахуун	7,612,000.00	10,884,336.37	3,272,336	143%
5	Тээврийн зардал	27,520,000.00	50,998,500.00	23,478,500	185%
6	Гэрэл цахилгаан	28,065,588.00	36,062,118.14	7,996,530	128%
7	Бичиг хэрэг	650,000.00	437,490.89	(212,509)	67%
8	Цахилгаан холбоо	300,000.00	300,000.00	-	100%
9	Албан томилолт	355,000.00	354,000.00	(1,000)	100%
10	Тэтгэмж урамшууллын зардал	3,000,000.00	3,268,018.18	268,018	109%
11	Хөдөлмөр хамгаалал	6,941,300.00	6,090,113.64	(851,186)	88%
12	Урсгал засвар	14,258,019.00	23,993,018.18	9,734,999	168%
13	Төлбөр хураамж	10,839,065.00	7,794,662.00	(3,044,403)	72%
14	Нохой устгалын зардал	1,000,000.00	990,000.00	(10,000)	99%
15	Үл хөдлөх хөрөнгийн зардал	1,476,480.00	1,476,480.00	-	100%
16	Бусад зардал	1,737,200.00	1,737,200.00	-	100%
17	Элэгдлийн зардал	-	45,009,744.71	45,009,745	0%
18	Нийт үйл ажиллагааны зардлын дүн	319,317,526.90	393,110,497.59	73,792,971	123%
19	Үйл ажиллагааны бус орлого, зардал		915,854.34	915,854.34	0%
20	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	25,186,365.10	(58,598,062.17)	(83,784,427.27)	-233%

ГУРАВ. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 107.4 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 7.9 сая төгрөгийн алдааг залруулж, 99.5 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгч, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх нийт 2 зөвлөмж өглөө.

Аудитаар залруулагдаагүй зөрчилтэй асуудлын материаллаг алдаа зөрчил нь 3.1 сая төгрөг бөгөөд тогтоосон материаллаг байдлын дүн 5.5 сая төгрөгөөс бага байгаа тул байгаа тул **Өөрчлөлтгүй** дүгнэлт өглөө.

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- НӨАТ тайлангаарх борлуулалтын орлого, санхүүгийн тайлангийн борлуулалтын орлогыг 7.9 сая төгрөгөөр илүү тайлагнасныг тайлангийн хугацаанд залруулсан.

5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Цалингийн зардалтай холбоотой

Илрүүлэлт: НДШ-ийн тайланд ажиллагсдын кодыг 3.1 сая төгрөгийн зөрүүтэй илгээсэн нь НДШ-ийн тухай хуулийн 18-р зүйлийн 18.1 “Ажил олгогч болон энэ хуулийн 7.2, 7.3, 7.4, 7.5-д заасан даатгуулагч дараах хувь хэмжээгээр сар бүр нийгмийн даатгалын шимтгэл төлнө” НББ-ийн тухай хуулийн 5.1.4 “Үнэн зөв байх” гэсэн заалтуудтай нийцээгүй бөгөөд “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цалингийн тооцооллыг үнэн зөв тооцоолж, ажил хариуцсан ажилтны ажлын хариуцлагыг сайжруулж ажиллах

2. Худалдан авалттай холбоотой

Илрүүлэлт: Худалдан авалттай холбоотой 96.4 сая төгрөгийн гүйлгээ нь анхан шатны баримттай боловч цахим и-баримтгүй байгаа нь орлогын албан татварын тухай хуулийн 13-р зүйлийн 13.1.4; “Доор дурдсан бараа, ажил, үйлчилгээний зардал Татварын ерөнхий хуулийн 28.5-д заасан дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримт, импортын бараанд татвар ногдуулж, гаалийн байгууллагад төлсөн тухай баримтаар баталгаажсан байх” НББ-ийн тухай хуулийн 14-р зүйлийн 14.3.1. “Анхан шатны баримт бүрдүүлэх” гэж заасныг тус тус зөрчсөн ба нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Татварын ерөнхий хуулийн 28.5-д заасан дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг баталгаажуулж байх

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5. Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ гэж заасны дагуу аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж ажиллах ажлын төлөвлөгөөг боловсруулан 2024 оны 04 дугаар сарын 25-ний өдрийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 30-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

ДӨРӨВ. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/сая төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
							Залруулсан		Залруулаагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
НӨАТ-ын тайлангаарх борлуулалтын орлого, санхүүгийн тайлангаарх борлуулалтын орлогоос 7.9 сая төгрөгөөр илүү тайлагнасан	1	7.9			1	7.9	1	7.9		
Дүн	1	7.9			1	7.9	1	7.9		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
НДШ-ийн тайланд ажиллагсдын кодыг 3.1 сая төгрөгийн зөрүүтэй илгээсэн	1	3.1					1	3.1
Худалдан авалттай холбоотой цахим и-баримтгүй гүйлгээ хийсэн	1	96.4					1	96.4
дүн	2	99.5					2	99.5

ТАВ. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ БА САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН НЭГТГЭЛ

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс тагталзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1				1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1				1			